

Түүх 2 : Адам ба Ева

Библийн эшлэл
[Эхлэл 1:27]

Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж,
Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ.

Бурханы бүтээсэн Еден цэцэрлэгийн голд амийн мод болон сайн мууг мэдүүлэгч мод ургадаг байлаа.

Еден цэцэрлэгт Адам аз жаргалтай амьдарч байв. Бурхан Адамд айлдав.

“Сайн мууг мэдүүлэгч модны жимснээс яасан ч идэж болохгүй. Тэр жимсийг идвэл та нар зайлшгүй үхэх болно.” Адам Бурханы үгэнд дуулгавартай байлаа.

Нэгэн өдөр Бурхан Адамыг унтаж байхад нь хавирганаас нь авч эмэгтэй хүнийг бүтээв.

Тэгээд тэр эмэгтэйг Ева гэж нэрлэжээ. Гэтэл нэгэн өдөр могой Ева дээр ирэв.

Могой – Адам болон Ева хоёрыг хуурч, Бурханы үгэнд дуулгаваргүй хандуулж сайн мууг ялгах модны жимснээс идүүлснээр гэм нүгэлд унагаах хорон муу санаа агуулж байлаа.

Ева сайн мууг мэдүүлэгч модонд очоод харахад жимснүүд нь үнэхээр идчихмээр амттай харагдаж байлаа.

Ева эцэст нь жимснээс аваад идчихэв. Тэгээд Адамд өгөхөд тэр бас иджээ.

Гэтэл сонин зүйл болжээ. Адам, Ева хоёр бие биенээ нүцгэн байгааг хараад ичицгээв.

Тэгээд тэд биеэ навчаар далдлан модны ард нуугджээ. Энэ бүх зүйлийг мэдсэн Бурхан маш их гүниглав.

Бурхан Адамыг хайж ирэв.

Бурхан, Өөрийнх нь тушаалыг сахиагүй Адам, Ева хоёрт мөн тэр хоёрыг хуурсан могойд шийтгэл оноожээ. Тэр хоёр Бурханы тушаалыг зөрчсөн ч Бурхан тэр хоёрт хайртай хэвээр байсан бөгөөд эцэс хүртэл тэднийг халамжилж байв.



Доорх хуудсанд байгаа нүд, хамар, амыг хайчлан авч Адам болон Ева хоёрын нүүрэнд зөв байрлуулан наана уу.



- Дараах библийн эшлэлийг дээр нь дагаж бицээд цээжлээрэй. (Эхлэл 1:27)

Бурханы дүр төрхийн дагуу хүнийг бүтээжээ.



